



НИЙСЛЭЛИЙН
БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 18 өдөр

Дугаар A/161

Улаанбаатар хот

2023-2024 оны хичээлийн жилийн
хамран сургах тойрог тогтоох, ажлын
хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Боловсролын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр анги, цэцэрлэгийн хамран сургах тойрог тогтоох ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга

Гишүүд:

Улсын бүртгэлийн хэлтсийн дарга

Статистикийн хэлтсийн дарга

Цагдаагийн хэлтсийн дарга

Хороодын Засаг дарга нар

Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн Боловсрол, соёл үрлагийн асуудал хариуцсан мэргэжилтэн Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн захирлууд,

Цэцэрлэгийн эрхлэгч нар

Боловсролын хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга:

2. Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хамран сургах тойргийг элсэгчдийн тоо, анги дүүргэлт, хүүхдийн сургууль руу ирэх, очих замын аюулгүй байдал, хоорондын зайд зэргийг харгалзан тогтоохыг Ажлын хэсэгт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.ДАВААСҮРЭН

